



## “Алслагдсан хөдөөгийн малчдын хүүхдүүдийн бага боловсролын үр дүнг сайжруулах нь” төсөл (2012-2017)

ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТОВЧ МЭДЭЭЛЭЛ

2016 оны 3-р улирал



# БОЛОВСРОЛ СОЁЛ, ШИНЖЛЭХ УХААН, СПОРТЫН ЯАМ



*Зураг дээр зүүн гараас Ц.Гэрэлтуяа, н.Уянга, Э. Энх-Амгалан,  
Т.Мицуаки, Ж.Батсуурь, Г.Цолмон, Э.Тэлмэн*



## БСШУС-ЫН САЙД Ж.БАТСУУРТ ТӨСЛИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ТАЛААР ТАНИЛЦУУЛАВ

Японы Хүүхдийг Ивээх Сангийн Монгол дахь захирал Мицуаки Тоёода, Боловсролын хөтөлбөрийн менежер Ц.Гэрэлтуяа нар 2016 оны 9 дүгээр сарын 30-ны өдөр БСШУС-ын сайд Ж.Батсуурьтай уулзаж, Хүүхдийг Ивээх Сангийн Монгол дахь хөтөлбөрийн боловсролын чиглэлээр хэрэгжүүлж буй төслүүдийн талаар танилцууллаа. Мөн цаашид хэд хэдэн чухал асуудлаар боловсролын салбарт хамтарч ажиллах хүсэлтэй байгаа талаар байр сууриа илэрхийлэв. Ялангуяа малчдын хүүхдийг боловсролын үйлчилгээнд хамруулахад “Алслагдсан хөдөөгийн малчдын хүүхдүүдийн

бага боловсролын үр дүнг сайжруулах нь” төслийн туршлагыг үндэсний хэмжээнд түгээн дэлгэрүүлэх ажлыг дэмжиж, хамтран ажиллахыг хүсэв. Уулзалтад БСШУСЯ-ны Гадаад хамтын ажиллагааны хэлтсийн дарга Э.Энх-Амгалан, мэргэжилтэн Д.Гарьд, төсөл, хөтөлбөр хариуцсан мэргэжилтэн н.Уянга, Хүүхдийг Ивээх Сангийн “Нэгдүгээр ангийн сурагчдын суралцах чадварыг дэмжихэд чиглэсэн сургуулийн чадавхийг бэхжүүлэх нь” төслийн зохицуулагч Г.Цолмон, “Хүүхэд залуучуудад бизнес, аж ахуй эрхлэх үр чадвар олгох” хөтөлбөрийн зохицуулагч Э.Тэлмэн нар оролцлоо.

## ОРОН НУТГИЙН УДИРДЛАГУУД ЭРДМИЙН БАЯРЫН НЭЭЛТЭД ОРОЛЦОО



сургуульд бэлтгэх хөтөлбөрөөр хичээллэн 1-р ангид орж буй хүүхдүүд, тэдний эцэг эх, сургуулийн дотуур байранд амьдардаг, хичээлийн бус цагийн нэмэлт хөтөлбөрт хамрагдаж, “Хүүхэд хөгжлийн танхим”-аар үйлчлүүлдэг хүүхдүүд, тэдний эцэг эх, багш нартай уулзаж, сэтгэгдлийг нь сонсож, санал бодлоо солилцлоо.

Архангай аймгийн засаг дарга Ц.Мөнхнасан Өндөр-Улаан сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2016-2017 оны хичээлийн жилийн нээлтийн арга хэмжээнд оролцож тус суманд хэрэгжиж буй төслийн үйл ажиллагаатай танилцан, хөдөөгийн малчдын хүүхдүүдийн боловсролын асуудлыг шийдвэрлэх төрийн үйл ажиллагаанд үнэтэй дэмжлэг үзүүлж байгаад талархаж буйгаа илэрхийлээд цаашид хамтран ажиллаж, төслийн үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэн ажиллахаа илэрхийллээ. Тэрээр гэр бүлийн орчинд



*Ц.Мөнхнасан ГБОСБХ-өөр хичээллэж буй хүүхдүүд, тэдний эцэг эхтэй уулзаж ярилцаж буй нь*



Сүхбаатар аймгийн засаг даргын орлогч Т.Амарбат Баяндэлгэр сумын ерөнхий боловсролын сургуулийн 2016-2017 оны хичээлийн шинэ жилийн нээлтэд оролцож, төслийн хүрээнд байгуулагдсан «Миний номын өргөө», «Хүүхэд хөгжлийн танхим», «Бага боловсрол нөхөн олгох сургалтын танхим»-уудын үйл ажиллагаатай танилцав. Тэрээр “Төсөл дуусахад жил хүрэхгүй хугацаа үлдсэн байна. Гэсэн хэдий ч эдгээр танхимын үйл ажиллагааг цаашид тогтвортой үргэлжлүүлэх чадвартай бэлтгэгдсэн хүний нөөц байгаа учир орон нутгаас ном, тоглоом, сургалтын материал, эд хогшлыг шинэчлэх тал дээр санаачилга гарган идэвхитэй хамтран ажиллах нь зүйтэй” гэдгийг онцлоод “Гэр бүлийн орчинд сургуульд бэлтгэх хөтөлбөр, Хичээлийн бус цагийн нэмэлт хөтөлбөр, Бага боловсрол



Баяндэлгэр сумын ЕБС-ийн захирал М.Мажигсүрэн ЗД-ын орлогч Т.Амарбатад даргад “Хүүхэд хөгжлийн танхим”-ын үйл ажиллагааг танилцуулж байгаа нь. Баруун гараас М.Мажигсүрэн, Ч.Амарбат, Б.Амарсүрэн



Аймгийн засаг даргын орлогч Т.Амарбат хичээлийн шинэ жилийн нээлтэд үг хэлэв

нөхөн олгох хөтөлбөрийн шинэлэг, үр өгөөжтэй аргагүйг аймгийн Аймгийн засаг даргын орлогч Т.Амарбат хичээлийн шинэ жилийн нээлтэд үг хэлэв хэмжээнд түгээн дэлгэрүүлэх сургалтыг бүсчлэн зохион байгуулах боломж байгаа” гэдгийг дурдав. Мөн гэр бүлийн орчинд сургуульд бэлтгэх хөтөлбөрөөр хичээллэн сургуульд элсэн орж буй 1-р ангийн хүүхдүүдэд талархлын бичиг, бичиг хэргийн зүйлс өгч, төслөөс хэвлэн гаргасан “Бүтээлийн ном”-ыг шүлэг, бүтээл нь багтсан хүүхдүүдэд дурсгал болгон гардууллаа.



## ТӨСЛИЙН ШИНЭ САНААЧИЛГЫГ ТҮГЭЭН ДЭЛГЭРҮҮЛЭХЭД АНХААРЧ АЖИЛЛАНА

Дорнод аймгийн Боловсрол, соёл, урлагийн газраас санаачлан 2016 оны 9 сарын 21-ний өдөр төсөл хэрэгжиж буй Матад, Чойбалсан, Халхгол, Сэргэлэн, Цагаан-Овоо сумын ерөнхий боловсролын сургуулийн захирал, цэцэрлэгийн эрхлэгч, ОНБЗ-ийн дарга нарыг оролцуулсан уулзалтыг БСУГ-ын байранд зохион байгууллаа. Оролцогчид уулзалтын үеэр төслийн Гэр бүлийн орчинд сургуульд бэлтгэх хөтөлбөр, Хичээлийн бус цагийн нэмэлт хөтөлбөр, Бага боловсрол нөхөн олгох хөтөлбөрийн хүрээнд гарч буй үр дүнг нэгтгэн үнэлж, дүгнэв. Гол үр дүн нь 5 настай хүүхдүүд гэр бүлийн орчинд сургуульд бэлтгэх хөтөлбөрөөр хичээллэснээр сургуульд амжилттай бэлтгэгдэж, сурлагын амжилт гарч байгаа бол хүүхдээ хөгжүүлэхэд малчин эцэг эхчүүдийн оролцоо нь эрс нэмэгдэж байна. Мөн гэр бүлээсээ тусдаа айлд болон сургуулийн дотуур байранд амьдарч буй хүүхдүүд хичээлийн бус цагийн нэмэлт хөтөлбөрт хамрагдсанаар сурлагын чанарт нь ахиц гарч байна. Сургуульд сураагүй, бага ангиас сургууль завсардсан хүүхдүүд бага боловсрол нөхөн олгох хөтөлбөрт хамрагдсанаар бага боловсрол эзэмшин, улмаар сургуульдаа эргэн орсон хүүхдүүдийн



*Дорнод аймгийн БСУГ-ын дарга О.Байгалмаа*

тоо нэмэгдсээр байна. Тиймээс төсөл хэрэгждэггүй бусад суманд эдгээр хөтөлбөрийг түгээн дэлгэрүүлэх нь чухал гэдэгтэй оролцогчид санал нэгдэн, шаардагдах хөрөнгийн асуудлын талаар тухайн сум, орон нутгийн удирдлагуудтай уулзаж, боломжийг судлахаар шийдвэрлэн уулзалтыг өндөрлөлөө.



*Уулзалтын оролцогчид*

Архангай аймгийн Хангай сумын  
ОНБЗ-ийн нарийн бичгийн дарга  
Д.Гантулга:



## ӨГӨӨЖ ИХТЭЙ ТӨСЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААГ СУМАНДАА НУТАГШУУЛАХААР СЭТГЭЛ ШУЛУУДАН АЖИЛЛАЖ БАЙНА

“Алслагдсан хөдөөгийн малчдын хүүхдүүдийн бага боловсролын үр дүнг сайжруулах нь” төсөл манай суманд хэрэгжсэн нь анхны төсөл юм. Төсөлд хамрагдсанаар хүүхэд, эцэг эх, багш нарын мэдлэг, чадвар сайжирч, төслийн үр шимийг бодитоор хүртэж байна. Үүний нэг баталгаа нь миний бие юм. Би сумын ОНБЗ-ийн нарийн бичгийн даргын албыг хашихын зэрэгцээ хичээлийн бус цагийн нэмэлт хөтөлбөрийн сургагч багшаар бэлтгэгдсэн. Ингэснээр сурч, мэдсэн зүйл ихтэй болж, үүнийг дагаад нийгэмд эзлэх байр суурь маань ч нэмэгдсэн. Өнгөрсөн хугацаанд олон нийтийн санаачилгыг дэмжих 3 тэтгэлэгт төслийг амжилттай хэрэгжүүллээ. Энэ туршлагадаа үндэслээд БСШУСЯ-ны хэрэгжүүлж буй “Баруун бүсийн бага сургуулийн дотуур байрны орчныг сайжруулах” төслөөс зарласан уралдааны удирдамжийн дагуу сургуулийнхаа дотуур байрны орчныг сайжруулахаар бичсэн төсөл маань шалгарч, санхүүгийн дэмжлэг авахаар болсон. Энэ 9 сараас тэр төсөл маань хэрэгжиж эхэлнэ. Оюунд минь үнэтэй хөрөнгө оруулалт хийж, байнга чадавхуулж байдаг төслөө сумандаа нутагшуулан авч үлдэх, түгээн дэлгэрүүлэхээр сэтгэл шулуудан ажиллаж байна”.



## ГЭР БҮЛИЙН ОРЧИНД СУРГУУЛЬД АМЖИЛТТАЙ БЭЛТГЭГДСЭН МАЛЧИН ӨРХИЙН 969 ХҮҮХЭД НЭГДҮГЭЭР АНГИД ЭЛСЭН ОРЛОО

Өнгөрсөн жил төслийн зорилтот 30 суманд малчин өрхийн 1,103 хүүхэд гэр бүлийн орчинд сургуульд бэлтгэх хөтөлбөрт хамрагдан хичээллэснээс 2016-2017 оны хичээлийн жилд 969 хүүхэд нэгдүгээр ангид элсэн суралцаж байна. Сургуульд амжилттай бэлтгэгдсэн эдгээр хүүхдийг төслийн зүгээс урамшуулан талархлын бичиг гардуулж, эрдмийн их аянд нь өндөр амжилт хүслээ. Эдгээр хүүхдийн зармаас онцолбол:

Архангай аймгийн Эрдэнэмандал сумын малчин Тогтохбаярын хүү Пүрэвдорж цэцэрлэгт огт явж байгаагүй, 2015 оны 10-р сараас төслийн гэр бүлийн

орчинд сургуульд бэлтгэх хөтөлбөрт хамрагдаж 10 багц, 96 өдрийн хичээлээ бүрэн дуусаад энэ 9 дүгээр сард 1-р ангийн сурагч болоод буй нь энэ. Анги удирдсан багш Д.Болор-Эрдэнэ “Т.Пүрэвдорж маш сайхан цэвэр бичигтэй, ангийн хүүхдүүдтэйгээ их эвсэг, сэтгэхүй хөгжүүлэх тоглоомонд илүү дуртай. “Би чадна” номоосоо сурсан дуу, шүлэг, үлгэрээ ангийнхандаа ярих дуртай. Хэл ярианы хөгжил, сурсан, мэдсэн зүйлсээрээ цэцэрлэгт хамрагдсан бусад хүүхэдтэй эн тэнцэхүйц байгаа нь гэр бүлийн орчинд сургуульд сайтар бэлтгэгдсэний баталгаа юм” хэмээн ярьж байв.

Т.ПҮРЭВДОРЖ:

### “БИ ДАНДАА ТАВАН ХОШУУ АВЧ БАЙГАА”



Харин Т.Пүрэвдорж хүү “Манай багш намайг дандаа “сайн байна” гэж хэлдэг. Би дандаа таван хошуу авч байгаа. Сургуульд орохоосоо өмнө аав ээжтэйгээ хамт номын санд ирж багцаа сольдог байсан. Тэгээд

сургуулийнхаа номын санг сайн мэддэг болохоор ангийнхаа хүүхдүүдэд хаана байдгийг нь зааж өгсөн. Би ном, тоглоомын багц ашиглаад шилдгийн шилдэг хүүхдээр шалгарч алтан медаль, бэлэг авч байсан. Бас “Цуутын цагагч гүү”, “Болдоггүй бор өвгөн”, “Балхүү үнэнээ хэлсэн нь” гээд их олон үлгэр мэддэг болсон. Том болоод уяач болно. Манай аав морь сайн уядаг” гэж ярилаа.





*А.Ижилбаатар, А.Ижилбилэг нар гэртээ хичээллэж байгаа нь*

Дорнод аймгийн Сэргэлэн суманд ихэр ах дүү А.Ижилбаатар, А.Ижилбилэг нар сумынхаа бага сургуульд элсэн орж сургуулийн сурагчид боллоо. Тэд хамтдаа гэр бүлийн орчинд сургуульд бэлтгэх хөтөлбөрөөр хичээллэн 96 өдрийн хөтөлбөр, 10 багцаа бүрэн судалж, дууссан.

Хамтдаа хичээллэх нь ганцаараа хичээллэснээс илүү сонирхолтой, үр дүнтэй болохыг эцэг эх, багш нар нь хэлж байлаа. Тэд 1-10 хүртэл чөлөөтэй тоолж, 12 жилээ нэрлэж, ертөнцийн зүг чиг мэддэг болж, нэрээ бичиж чаддаг болсон төдийгүй олон дуу, шүлэг, үлгэр сүрчээ. Ихрүүд одоо сумынхаа ерөнхий боловсролын сургуулийн дотуур байранд амьдарч байна. Тэднээс гадна төслийн сургуульд бэлтгэх хөтөлбөрөөр хичээллээд 1-р ангид орсон 4 хүүхэд дотуур байранд амьдарч байна.



*Зүүн гар талаас Б.Эгшиглэн, А.Ижилбилэг, Э.Хишигбаяр, Б.Дэлгэрмаа, М.Бярманцог, А.Ижилбаатар нар “Хүүхэд хөгжлийн танхим”-д хичээллэж байгаа нь*



Өвөрхангай аймгийн Богд сумын хувьд гэр бүлийн орчинд сургуульд бэлтгэх хөтөлбөрөөр хичээллэсэн 68 хүүхэд сумынхаа ерөнхий боловсролын сургуулийн 1-р ангид элсэн орлоо.

9 дүгээр сарын 1-нд сургуулийн хамт олон эдгээр хүүхдийг аав, ээж, ах, эгч, өвөө, эмээ, найзуудтай нь хүлээн авч, талархлын бичиг гардуулан, хөтөлбөрийн номуудаа хамгийн ариг гамтай хэрэглэсэн болон хүүхдэдээ хамгийн их цаг гаргаж, хариуцлагатай ажилласан эцэг эхчүүдийг алдаршуулан, хүүхдүүд юу сурснаа цугласан олонд үзүүлсэн сайхан үйл ажиллагааг зохион байгууллаа.

Мөн хүүхэд, эцэг эхчүүдийг дотуур байрын “Хүүхэд хөгжлийн танхим”-ын үйл ажиллагаатай танилцуулав. Гэр бүлийн орчинд сургуульд бэлтгэгдсэн хүүхдүүдийн талаар 1в ангийн анги удирдсан багш Ц.Цагаангантиг “тус хөтөлбөрөөр хичээллэсэн хүүхдүүд маань илүү бие даасан, багшийн өмнө биеэ барихгүй, асуусан асуултанд бусдаасаа түрүүлэн хариулж байна” гэж онцлон ярьж байлаа.



*Богд сумын ЕБС-ийн захирал Т.Цэрэнлхам (голд), ОНБЗ-ийн дарга (зүүн гар талд) Ц.Дуламсүрэн нар охин Батцэцэгийнхээ ном, тоглоомын багцыг солиход үргэлж хамт ирдэг аав н.Эрдэнэбатад талархал гардууллаа.*



*Эцэг эхчүүд, хүүхдүүдийн хамт “Хүүхэд хөгжлийн танхим”-аар зочилж, үйл ажиллагаатай нь танилцлаа*



*1-р ангид элсэн орсон Б.Оюунбаяр, Б.Болорчимэг нар сурсан дуу, шүлгээ бусдадаа дуулж, уншиж өглөө.*

# БАРИМТАТ КИНОНД БАГА НАСАА МӨНХӨЛЛӨӨ

“Алслагдсан хөдөөгийн малчдын хүүхдүүдийн бага боловсролын үр дүнг сайжруулах нь” төсөл хэрэгжсэнээр Архангай, Өвөрхангай, Дорнод, Сүхбаатар аймгийн зорилтот 30 сумын малчин өрхийн цэцэрлэгт хамрагдах боломжгүй 5 настай хүүхдүүд эцэг эх, чиглүүлэгч багшийн тусламжтайгаар гэртээ тусгайлан боловсруулсан хөтөлбөр буюу гэр бүлийн орчинд сургуульд бэлтгэх хөтөлбөрийн дагуу сургуулийн өмнөх боловсролыг эзэмших бүрэн боломжтой болсон юм. Энэхүү туршлага нь цаашид түгээн дэлгэрүүлэхүйц сайн туршлага болж, Монгол төдийгүй олон улсад ч



сонирхон, энэхүү туршлагыг ижил төстэй улс оронд танилцуулах хэд хэдэн ажлууд өнгөрсөн хугацаанд хийгдлээ. Үүний нэг нь Японы Хүүхдийг Ивээх Сангийн зураг авалтын багийнхан Монгол улсад хүрэлцэн ирж, төслийн үйл ажиллагаа хөдөөгийн малчин хүү болон тэдний гэр бүлд хэрхэн нөлөөлж байгааг харуулах баримтат киноны зургийг хүүхдийн бодит амьдралд түшиглэх авлаа. Гэр бүлийн орчинд сургуульд бэлтгэх хөтөлбөрөөр амжилттай хичээллэн, сумынхаа ерөнхий боловсролын сургуулийн 1-р ангид орж буй Архангай аймгийн Өлзийт сумын Бодонт багийн иргэн Жаргалсайханы Анхныбаяр уг баримтат киноны гол дүр байлаа. Ж.Анхныбаярын аав, ээж хүүдээ маш их цаг гаргаж, хүү ч өөрөө ихээхэн хичээж, чармайсны хүчинд ийнхүү олон улсын хэмжээний гадаадын баримтат кинонд үе тэнгийн найзуудаа, Монгол орноо төлөөлөн

оролцох боломжийг олгов. Киноны багийнхан хэдэн өдрийн турш Ж.Анхныбаяр хүүгийн малчны амьдралын эгэл жирийн өдрүүд, сургуульд орох бэлтгэл, орохын өмнөх өдрийн үйл явдал, 9 сарын 1-ний өглөө аав, ээжийн хамт сургуульд элсэн суралцахаар явж буй болон сумын сургуулийн хичээлийн шинэ жилийн нээлт зэрэг олон үйл явдлыг зураглан хальсанд буулгасан юм. “Том болоод аав ээждээ ачлалтай, сум орондоо ихийг бүтээх сайн хүн болно” хэмээн хэвлүүхэн ярьж сүүх түүнийг өөр шигээ олон найз нартаа урам өгөх, “хичээвэл ямар ч амжилтад хүрч болдог” –ийн бодит жишээ болоход нь аав ээж, чиглүүлэгч багш, ОНБЗ-ийнхөн, “БИ ЧАДНА” ном нь хамгийн гол туслагч нар нь болсон байна. Түүнчлэн киноны багийнхан 2013-2014 оны хичээлийн жилд гэр бүлийн орчинд сургуульд бэлтгэх хөтөлбөрт хамгийн анх хамрагдаж, эрдмийн гараагаа эхлүүлсэн, одоо 3-р ангид суралцаж буй сургуулийн тэргүүний, олон олон медиалийн эзэд болсон хүүхдүүдтэй уулзаж, ярилцлаа. Хүүхдүүд хичээлийн хоцрогдолгүй, амжилттай суралцахад нь мөн л төслийн хичээлийн бус цагийн нэмэлт хөтөлбөр ихээхэн нөлөөлдөг, хөтөлбөрийн хүрээнд олон сайхан үйл ажиллагаанд хамрагдаж, тэр хэрээр хувь хүний хувьд хөгжиж, хичээл, сурлагадаа амжилт гаргадаг тухайгаа ам уралдан ярьж байлаа.

Өвөрхангай аймгийн Уянга сумын ОНБЗ 2016 оны 9 дүгээр сарын 04-ний өдөр төслийн гэр бүлийн орчинд сургуульд бэлтгэх хөтөлбөрт хамрагдаад, 2016-2017



*Ж.Анхныбаяр зурагч болохын өмнө болон дараа*



## 1-Р АНГИД ЭЛСЭН ОРСОН, ХБЦНХ-Т ХАМРАГДДАГ СУРАГЧДЫН ДУНД СПОРТЫН УРАЛДААН ЗОХИОН БАЙГУУЛАГДАВ

*Тэмцээнд оролцогч 1-р ангийнхан*

оны хичээлийн жилд 1-р ангид элсэн орсон, хичээлийн бус цагийн нэмэлт хөтөлбөрт хамрагддаг, айлд болон дотуур байранд амьдардаг сурагчдыг илүү идэвхжүүлэх зорилгоор дунд спортын олон төрөлт тэмцээнийг ерөнхий боловсролын сургуулийн захиргаатай хамтран амжилттай зохион байгуулав. Нийт 65 хүүхэд уртын харайлт, 60 метрийн гүйлт, бөмбөг шидэлт зэрэг төрөлд авхаалж, самбаа, хурд, хүчээ сорин өрсөлдлөө. Тэмцээнийг аймгийн шагайн харвааны гоц мэргэн Б.Ганзориг, спортын мастер Д.Эрдэнэчулуун нар ивээн тэтгэж, тэмцээнд оролцсон нийт тамирчдад дурсамж,

дурсгалын зүйлс гардуулан өглөө. 60 метрийн гүйлтийн төрөлд 1-р байранд 16 ангийн сурагч Х.Золбаяр, 2-р байранд 16 ангийн сурагч Т.Болдсайхан, 3-р байранд 1а ангийн сурагч Б.Ганжаргалнар харин тэмцээний уртын харайлтын төрөлд 1-р байранд 16 ангийн сурагч Р.Пүрэвдолгор, 2-р байранд 16 ангийн сурагч Б. Налжирмаа, 3-р байранд 1а ангийн сурагч М.Номин нар шалгарлаа. Байрнаас уртын харайлтын төрөлд 1-р байранд 3в ангийн сурагч Б. Болормаа, 2-р байранд 3б ангийн сурагч Б. Лхагвадулам, 3-р байранд 3а ангийн сурагч Л. Пүрэвжаргал шалгарчээ.



*60 метрийн гүйлтийн төрөлд 1-р байранд 16 ангийн сурагч Х.Золбаяр, 2-р байранд 16 ангийн сурагч Т. Болдсайхан, 3-р байранд 1а ангийн сурагч Б. Ганжаргал нар 2-р сургуулийн захирал Э.Туул (зүүн гараас хоёрдахь)-аас шагналаа гардан авлаа*



*Уртын харайлтын төрөлд 1-р байранд 16 ангийн сурагч Р. Пүрэвдолгор, 2-р байранд 16 ангийн сурагч Б. Налжирмаа, 3-р байранд 1а ангийн сурагч М.Номин нар шалгарлаа*





## ОНБЗ-ИЙН ГИШҮҮД ЧАДАВХИ БЭХЖҮҮЛЭХ СУРГАЛТАД ХАМРАГДАВ

“Алслагдсан хөдөөгийн малчдын хүүхдүүдийн бага боловсролын үр дүнг сайжруулах нь” төслийн зүгээс 2016 оны 9 сарын 10-12-ны өдрүүдэд Улаанбаатар хотноо Архангай, Өвөрхангай, Дорнод, Сүхбаатар аймгийн 30 сумын Олон нийтийн боловсролын зөвлөлийн гишүүд, Сүхбаатар дүүргийн Насан түршийн боловсролын төвийн 8 багш, нийт 38 багшид “Эцэг эх, гэр бүлийн боловсрол болон харилцаа” сэдэвт

сургалтыг амжилттай зохион байгууллаа. Сургалтаар хичээлийн явцад хүүхдийг идэвхжүүлэх, сэтгэхүй хөгжүүлэх, алжаал тайлах дасгал тоглоомууд, хүүхдийн сурах чадварыг тогтоох тест, эцэг эх хүүхдийнхээ

боловсрол, хүмүүжилд гүйцэтгэдэг үүрэг, хүүхдийн зүүн, баруун тархийг зэрэг хөгжүүлэх арга зэрэг багш нар өдөр тутмынхаа ажилд ашиглах хэрэгцээт мэдээллээр хангалаа. Сургалтын үеэр ОНБЗ-ийн гишүүд орон нутаг дахь төслийн үйл ажиллагааны талаар харилцан мэдээлэл солилцож, туршлагаасаа хуваалцан, тулгамдаж буй бэрхшээлээ даван туулах арга замын талаар харилцан санал солилцох, ярилцах боломж олгосон нь оролцогчдод ихээхэн үр дүнтэй байв. Гэхдээ сургалтад оролцогчдын зүгээс цаашид сурлагаар хоцорсон хүүхдүүдтэй ажиллах арга зүйн талаар сургалт, мэдээлэл авах хүсэлтэй байгаагаа илэрхийлж байв.





## ТОКИОГИЙН ИХ СУРГУУЛИЙН ДОКТОРАНТУР ЭРИ НАКАМУРА ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН БАЯНГОЛ, ТАРАГТ СУМДАД АЖИЛЛАЛАА

Эри Накамура анх 2014 оны 9 сард эцэг эхийн боловсролын талаар судалгаа хийхээр Монгол улсад ирж, Өвөрхангай аймгийн Баянгол, Тарагт суманд ажиллаж, төслийн гэр бүлийн орчинд сургуульд бэлтгэх хөтөлбөрт хамрагдсан хүүхдүүдийн эцэг эхэд зориулан хүүхдэдээ бага боловсролыг аль болох эрт олгохын ач холбогдол, ном, тоглоомын багцыг эцэг эх, хүүхдүүд хамтдаа хэрхэн зөв зохистой ашиглах аргачлалуудын талаар сургалт зохион байгуулж байсан. Сургалтад Баянгол сумын 30, Тарагт сумын 16 эцэг эх оролцсон бөгөөд харилцан туршлага солилцсон юм. Эри Накамура 2 жилийн дараа дахин Монгол улсад ирж, мөн л Өвөрхангай аймгийн Баянгол, Тарагт суманд 3 өдрийн турш ажиллалаа. Ингэхдээ 2014 онд сургалтад оролцсон эцэг эхчүүдтэй уулзаж, 2014 оноос хойш тэдэнд гарсан өөрчлөлт, үр дүнг үнэлэн, сумдын ОНБЗ-

тэй уулзаж, “Миний номын өргөө”, “Хүүхэд хөгжлийн танхим”, “Бага боловсрол нөхөн олгох тахим”-уудаар зочилж, үйл ажиллагаатай нь танилцлаа. Мөн хүүхэд нь гэр бүлийн орчинд сургуульд бэлтгэх хөтөлбөрт хамрагдаад одоо 2-р ангид сурч байгаа малчин өрхүүдэд зочилж, эцэг эхийн сэтгэгдлийг сонслоо. Эцэг эхчүүд “хүүхдүүд маань хөтөлбөрт хамрагдсанаар олон зүйл сурч, сургуульд орохдоо их баяртай байсан, бид ч хүүхдээ сургуульд өгөхөд цэцэрлэгт хамрагдаагүй гэж санаа зовох зүйлгүй байлаа. Гэр бүлийн орчинд сургуульд бэлтгэх хөтөлбөр малчин эцэг эх бидэнд хүүхдээ гэртээ сургуульд бэлтгэх сайхан боломжийг олгосон. Эцэг эх бид хүүхдийнхээ анхны багш болсондоо сэтгэл их өндөр байдаг. Хөтөлбөрийн хүрээнд өгсөн гарын авлага, ном, тоглоом хүүхдийн насанд таарсан, хэрэглэхэд их тохиромжтой байсан. Хоёр жилийн өмнө



*Тарагт сумын малчин Хүрэлбаатарийн Золбаатар, дүү нарын хамт*

Эри багшийн хичээлд суугаад хүүхэдтэйгээ хэрхэн ажиллах аргагүй сурч, эцэг эхчүүд хоорондоо туршлагаа харилцан хуваалцаж, саналаа солилцсон нь их үр дүнтэй байсан. Тиймээс хүүхэдтэйгээ ажиллах, ном, тоглоомын багцаа ашиглахад нэг их бэрхшээл тулгарсангүй” гэж ярьж байлаа. Эри Накамура “2014 онд Баянгол, Тарагт сумыг сонгон ирж ажилласан.

Тухайн үед гэр бүлийн орчинд сургуульд бэлтгэх хөтөлбөр хэрэгжиж эхлээд удаагүй байсан ч эцэг эхчүүд сургалтад идэвхтэй оролцож байсан. Энэ жил өмнө нь ажилласан хоёр суманд дахин ирж, сургалтад оролцсон эцэг эхчүүд, хүүхдүүдтэй уулзахад гэр бүлийн орчинд сургуульд бэлтгэх хөтөлбөр их үр дүнтэй, малчин эцэг, эхчүүд, хүүхдэд үр өгөөжтэй байсан нь харагдаж

байна. Баянгол сумын ОНБЗ, сургуулийн багш нар, ажилчид, эцэг эхчүүд бүгд сайн хамтарч ажиллаж байна. Тарагт сум аймгийн төвтэй ойрхон болохоор хүүхдүүд аймгийн төвийн сургуульд элсэн суралцдаг юм байна. Эцэг эхчүүдээс авсан судалгаа, тэдэнтэй хийсэн уулзалтаас харахад гэр бүлийн орчинд сургуульд бэлтгэх хөтөлбөрийн гарын авлага, ном, тоглоомын багцад их сэтгэл хангалуун байсан, эцэг эх, чиглүүлэгч багшийн хамтын ажиллагаа сайн байдаг нь харагдаж байна. Хүүхдэдээ боловсрол эзэмшүүлэх талаарх эцэг эхчүүдийн хандлага нь сайжирч, хүүхдээ сургуульд амжилттай сайн бэлтгэн оруулсныг хараад сэтгэл их хангалуун байна” гэж дүгнэж байв.



*Баянгол сумын малчин Д.Отгонбаатарын хүү О.Рэнцэндаваа, охин О.Рэнцэнханд нар ээж Майцэцэг, Эри Накамура нарын хамт*



### СҮХБААТАР АЙМГИЙН УУЛБАЯН СУМЫН ОНБЗ-ИЙНХӨН “АСАРТАЙ АЯЛАЛ” ЗОХИОН БАЙГУУЛАВ



Уулбаян сумын ОНБЗ-ийнхөн төслийн талаарх мэдээллийг малчдад шинэлэг хэлбэрээр хүргэсэн нь “Асартай аялал” байв. “Асартай аялал”-ыг сумын төвөөс 20 км-т орших Баян багийн шинэ барилгын нээлтийн үеэр зохион байгуулж, төслийн хэрэгжилт, хүрсэн үр дүн, хамрагдаж буй хүүхдүүдэд гарсан бодит өөрчлөлтүүдийн талаар цугласан олонд танилцууллаа. Энэ үеэр үр дүнгийн баяраар тавигдсан хүүхдүүдийн бүтээлийг үзэсгэлэн болгон үзүүлэв. Мөн малчид 4-5 настай хүүхдээ Гэр бүлийн орчинд сургуульд бэлтгэх хөтөлбөр, Хичээлийн бус цагийн нэмэлт хөтөлбөр, Бага боловсрол нөхөн олгох хөтөлбөрт хэрхэн хамруулах талаар ОНБЗ-

ийн гишүүдээс сонирхсон асуултаа асууж тодруулж байлаа. ОНБЗ-ийн гишүүд аав, ээжтэйгээ хамт ирсэн хүүхдүүд багцын ном, тоглоомуудаар тоглох, эцэг эхчүүд хүүхдэдээ үлгэрийн ном уншиж, өгөх боломжоор хангав.



### ДОРНОД АЙМГИЙН СЭРГЭЛЭН СУМЫН ОНБЗ “ТЭРГҮҮНИЙ ГЭР БҮЛ”-ИЙГ ШАЛГАРУУЛЖ-ХЭВШЖЭЭ

Тус сумын ОНБЗ гэр бүлийн орчинд сургуульд бэлтгэх хөтөлбөрийн хэрэгжилтийг эрчимжүүлэх, эцэг эхийн оролцоог нэмэгдүүлэх, тэднийг идэвхжүүлэх зорилгоор сар бүр “ТЭРГҮҮНИЙ ГЭР БҮЛ”-ийг шалгаруулж хэвшжээ. Ингэхдээ багцаа цаг хугацаанд нь тогтмол, идэвхтэй сольдог, ном, тоглоомоо цэвэр нямбай ашигладаг, хүүхдийнхээ хэл ярианы чадварыг сайжруулах, гарын жижиг бүлчинг хөгжүүлэх, юмны эв дүйг олдог болгох, зураг зурж сурахад нь цаг гаргаж чаддаг, баримлын шавар ашиглан хамтын бүтээл хийж, бүтээлийн сантай болж байгаа зэргийг нь шалгуур болгон тэргүүний гэр бүлээ шалгаруулдаг байна. Сар бүр “Тэргүүний гэр бүл” шалгаруулдаг болсноор олон эерэг өөрчлөлт гарсны хамгийн гол үр дүн нь эцэг эхчүүд хүүхдэдээ цаг гаргаж, гэр бүлийн тэгш оролцоо бий болж, илүү санаачилгатай ажилладаг болжээ.

## “АЛСЛАГДСАН ХӨДӨӨГИЙН МАЛЧДЫН ХҮҮХДҮҮДИЙН БАГА БОЛОВСРОЛЫН ҮР ДҮНГ САЙЖРУУЛАХ НЬ “ төсөл (2012-2017)



Төслийн санхүүжүүлэгч :

Төсөл хэрэгжүүлэгч:

Төслийн санхүүжилт:

Төслийн хугацаа:

Дэлхийн Банк, Японы Нийгмийн Хөгжлийн Сан

Японы Хүүхдийг Ивээх Сангийн Монгол дахь хөтөлбөр

2.5 сая ам.доллар

5 жил (2012-2017)

### Төслийн зорилго:

Архангай, Өвөрхангай, Дорнод, Сүхбаатар аймгийн алслагдсан 30 сумын 5-10 насны малчин өрхийн 7,500 орчим хүүхдийн бага боловсролын хүртээмж, чанар, үр дүнг сайжруулна.

### Төслийн зорилт:

1. Сургуульд шинээр элсэн орох 5 настай хүүхдүүдэд зориулсан гэр бүлийн орчинд сургуульд бэлтгэх хөтөлбөр шинээр боловсруулж, туршин нэвтрүүлнэ.
2. Гэр бүлээсээ тусдаа айл болон дотуур байранд амьдарч буй 6-10 насны хүүхдүүдэд зориулсан Хичээлийн бус цагийн нэмэлт хөтөлбөр боловсруулж, хэрэгжүүлнэ.
3. Сургуульд сураагүй болон бага ангидаа сургуулиас завсардсан 8-с дээш насны хүүхдүүдэд бага боловсрол нөхөн олгох сургалтын хөтөлбөр боловсруулж, туршин нэвтрүүлнэ.

---

### Хүүхдийг Ивээх Сан

Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,  
1-р хороо, Арizona төвийн 4-р давхар  
Утас: +976-11-329365, 329371  
Факс: +976-11329361

Шуудангийн хаяг: Төв шуудан, ш/х-1023

Улаанбаатар-13, Монгол Улс

Э-шуудан: [secretary@savethechildren.mn](mailto:secretary@savethechildren.mn)

Вэб хаяг: [www.savethechildren.mn](http://www.savethechildren.mn)

Facebook: Save the children in Mongolia

Twitter: Save the children MN